

“ESG FINANCE” JSC

“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 3 -р сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

“И Эс Жи Файнанс” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 3-р сарын 26-ны өдөр 11 цагт Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд хийж ба хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хурлыг тус Хурлын дарга М.Сайнболор нээв.

-Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд талархал илэрхийлье.. Та бүхэнд тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийг танилцуулъя. Компанийн нийт 374,018 ширхэг хувьцааны 90.2% буюу 337,624 ширхэг хувьцааг эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхлүүлье.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
7. Бусад.

Хурлын дэгийг танилцуулъя. Хуралаар хэлэлцэгдэх асуудлын жагсаалтын дагуу явагдана. Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – гийн талаар Гүйцэтгэх захирал М.Сайнболор танилцуулна.

Гүйцэтгэх захирал, хурлын дарга М.Сайнболор

Компанийн үйл ажиллагааг зогсонги байдлаас гаргах үүднээс үйл ажиллагааны үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах болон ногоон хөгжил, хиймэл оюун ухаан, финтек салбарт судалгааны ажил хийж байна. 2024 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзвэл, дараах байдалтай байна:

Компани мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зорин 5 шинэ ажилтан ажилд авч гэрээ байгуулаад байна. Бүгд мэдээллийн технолги, хиймэл оюун ухаанаар мэргэшсэн ажилтнууд байгаа. Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв зэрэг газруудад байсан урьд жилүүдийн гишүүнчлэл, хувьцаа хадгалалтын төлбөр, өрүүдийг төлж барагдуулсан.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үйл хүрээнд компанийн үйл ажиллагааны шинэ чиглэл болон стратегийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулах ажлууд шат дараатай зохион байгуулагдсан. БНХАУ-ын Evergreen банкттай хамтран ажиллахаар тохиролцон мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Ногоон хөгжил ESG, хиймэл оюун ухаан, мэдээлэлийн технологийн тодорхой хөрөнгө оруулалтын төслийн танилцуулга хөрөнгө оруулагчдад танилцуулсан.

Мөн гадны болон дотоодын компаниудад вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэх болон мэдээлэлийн технологийн шийдлийн зөвлөгөөг өгч байна.

Финтек технологийн хүрээнд блокчэйн технологи болон криптовалютыг судалж байна.

Тархмал бүтэцтэй байгууллага буюу блокчэйн бүтэцтэй холбоотой үүсэж болох өөрчлөлтийг эртнээс таниж мэдэх улмаар энэхүү өөрчлөлт компаниуд хэрхэн эрсдэлгүйгээр шилжин ороход зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүднээс этериум буюу ухаалаг гэрээний системийг судалж байна.

Бид цаашид: програм хангамжийн худалдаа эрхлэх, Бизнесийн удирдлага, Төслийн удирдлага, мэдээлэлийн Технологи болон Бизнес стратегитэй холбоотой мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багцтай болох, бизнесийн автоматжуулалт, өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөгөө өгөх, ESG ногоон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх, хамтрах, хиймэл оюун ухаанд суурилсан шинэ үйл ажиллагааг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлууд ихээхэн уаг хугацаа хөрөнгө мөнгө шаардсан ажлууд тул хугацаа их орж байна.

Санхүүгийн тайлангийн хувьд үйл ажиллагаа явуулаагүйгээр тайлагнасан байгаа.

Хурлын дарга М.Сайнболор: Та бүхэнд асууж тодруулах зүйл байна уу. Та бүхэнд тараагдсан байгаа үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн тайлантай танилцаад асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй ээ. Цаашид хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөг бүрэн дэмжиж байна.

Хурлын дарга М.Сайнболор: Компани ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн болно. Компанийн дүрэмд оруулах санал байна уу.

Хувьцаа эзэмшигч "Вистекс Глобал Инвест" ХХК-ийн захирал Камолиддин Талипов: Компани цаашид үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа тул таван тэрбум төгрөг хүртлэх төгрөгийн нэмэлт хувьцаа гаргах саналтай байна. Нэмэлт хувьцаа гаргаж байгаа нь гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орж байгаа нь дүрэмд өөрчлөлт оруулах нэг үндэслэл юм. Нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбоотойгоор тэргүүн ээлжинд хувьцаа авах эрхийг эдлүүлэхгүй байх саналтай байна. Мөн шаардах эрхийг хэрэгжүүлэх эрхийг ТУЗ-д өгөх саналтай байна.

Хувьцаа эзэмшигчид: Санал нэгтэй дэмжиж байна.

Хурлын дарга М.Сайнболор: –ТУЗ-ийн гишүүдийг сонгох хугацаа нь болсон тул нэр дэвшигчдийн танилцуулгыг та бүхэнд тараан өгсөн байгаа.

Хуралд оролцогчид – Нэмж хэлэх зүйл алгаа. Бүгдийг нь дэмжиж байна.

Хурлын дарга М.Сайнболор: За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

Хурлын дарга М.Сайнболор:– Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

“Силк Нэт” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 11.40 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ESG FINANCE

JSC

Хянасан: Хурлын дарга



Л.Дөлгөөн

М.Сайнболор